



БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА Т.НЯМ-ОЧИР
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, И-мэйл: letter@mecs.gov.mn
Вэб сайт: meds.gov.mn

2024.05.22 № 2/2165

танай _____-ны № _____-т


Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталж, эрх шилжүүлэх тухай” А/27 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт БШУЯ/2024040210 “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хүүхдийн ширээ, сандал, хувцасны шүүгээ, тоглоомын тавиур, вандан сандал, багшийн ширээ, сандал, бичгийн шүүгээ, эрхлэгчийн өрөөний ширээ, сандал, бичгийн шүүгээ худалдан авах” төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтод дараах тодруулгын хариу хүргүүлж байна.

Үүнд:

1. Хүүхдийн ширээ 3-4 насны хэмжээ "1000x600x520мм", 4-5 насны хэмжээ "1000x600x550мм", Хүүхдийн сандал 3-4 насны хэмжээ "310x280x535мм", 4-5 насны хэмжээ "310x280x600мм", Хүүхдийн сандлын суудал 3-4 насны хэмжээ "300x250x280мм", 4-5 насны хэмжээ "310x260x300мм" байх бөгөөд MNS 3742:1984 стандартад нийцүүлэх;
2. Багшийн бичгийн шүүгээний хаалга баруун болон зүүн 2 нээлхийтэй, шилгүй, төмөр рамгүй, мөлгөр булантай, хавтан материалтай байх;
3. STEAM /СТЕАМ/ сургалтын хэрэглэгдэхүүний хайрцгийн хэмжээг "милметр" хэмжигдэхүүнээр хэмжих;
4. “My mongolia” хөтөлбөр нь Монгол ахуй, өв соёл, түүх, газарзүйн онцлог, мал, амьтан, ёс заншлыг таниулах нийт 10 агуулга бүхий 45 ялгаатай загварыг угсрах зааврын дагуу хийгдсэн, бүтээнгээ үйлдэн суралцах боломжтой хэрэглэгдэхүүн байна. Мөн ахлах, бэлтгэл бүлгийн хүүхдүүдэд зориулсан Монголын уламжлалт сургалтын арга барил, хүүхдийн монгол хэл, тоо тооллыг хөгжүүлэх сонирхолтой баримтуудыг багтаасан, үүнтэй холбоотой бичлэг, дуу шүлэг, зураг, бие даан гүйцэтгэх материал зэрэг мэдээллийг технологи ашиглан өгөх боломжийг бүрдүүлсэн байна.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА  Ж.БАТЖАРГАЛ



14249 2418